



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/357

Мандалговь

Г Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилт, шинэчлэлт-2018 аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6"а", 29.2 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.1.1 дэхь заалт, Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.2 дахь заалт, Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалт, Улсын их хурлын 2017 оны 76 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


Нэг. Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллого, Үндэсний статистикийн хорооноос 2018 оны 10 сард зохион байгуулах "Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа"-ны бэлтгэл ажлын хүрээнд "Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилт, шинэчлэлт-2018" сарын аяныг зарлан зохион байгуулсугай.

Хоёр.Харъяа сум, багтаа сарын аяны удирдамж, заавар, аргачлалын дагуу ажлыг чанартай зохион байгуулж явуулахад багийн Засаг дарга нарын үүрэг, оролцоог нэмэгдүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

Гурав. "Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн шинэчлэлт-2018" сарын аяныг зохион байгуулж явуулах удирдамжийг нэгдүгээр, ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Дөрөв. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, сумдын удирдлагыг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Статистикийн хэлтсийн дарга (Б.Энхтуяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Ж.МӨНХЧУЛУУН

490010153

Аймгийн Засаг даргын, 2018 оны 08
дугаар сарын 23-ны өдрийн /32/ тоот
захирамжийн 1 дүгээр хавсралт

**ХҮН АМ, ӨРХИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН БАЯЖИЛТ, ШИНЭЧЛЭЛТ-2018
САРЫН АЯНЫ УДИРДАМЖ**

Зорилго: 2018 оны 9-11 сард зохион байгуулагдах 5 жилд нэг удаа явагддаг нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, 2020 оны Хүн ам орон сууцны тооллогын бэлтгэл ажлыг хангах зорилгоор ХАӨМС-д баяжилт, шинэчлэлт хийх, албан ёсны Статистик мэдээний чанарыг сайжруулах, багийн Засаг дарга нарын ажлын уялдаа холбоог бэхжүүлэхэд оршино.

Хамрах хүрээ: 15 сумын 66 багийн Засаг дарга, 15 Статистик хариуцсан мэргэжилтнүүд

Хугацаа: 2018 оны 08 сарын 22-ноос 9 сарын 22-ны хооронд /1 сар/

Шалгуур үзүүлэлт:

1. Анхан шатны статистик мэдээ, тайлангийн үнэн бодит байдал, чанар, баримтжуулалт, Өрхөд суурилсан судалгааны үндсэн өрхийн хамралт, ХАӨМС-тай уялдсан байдал,
2. Хүн ам өрхийн мэдээллийн сангийн баяжилт, шинэчлэлт, шилжилт хөдөлгөөнийг баталгаажуулсан байдал,
3. 7 хоног бүр программын хандалт, алдаа
4. Багийн засаг дарга нарыг идэвхижүүлэн, дэмжин тусалж, тайлагнасан байдал

Аяныг дүгнэх: Дээрх шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэн Багийн Засаг дарга нараас 3 хүн, Статистик хариуцсан мэргэжилтнүүдээс 1 хүнийг шалгаруулан урамшуулна.

Мөн дээрх үнэлгээ нь жилийн эцсийн ажил дүгнэх үнэлгээнд нөлөөлнө.

Статистикийн хэлтсээс доорх байдлаар сумдыг хуваарилан авч зөвлөн тусалж, хяналт хийх болно. Хариуцсан албан хаагчтай холбогдож дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.

1. Б.Энхтуяа /Хэлтсийн дарга/ - Өлзийт, Цагаандэлгэр, Говь-Угтаал,
2. Т.Бямбасүрэн /Ахлах мэргэжилтэн/ - Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэн,
3. С.Доржханд /Мэргэжилтэн/ - Сайнцагаан, Дэлгэрхангай, Гурвансайхан,
4. Н.Түвшинжаргал /Мэргэжилтэн/ - Эрдэнэдалай, Сайхан-Овоо, Өндөршил,
5. Г.Ариунжаргал /Мэргэжилтэн/ - Хулд, Луус, Баянжаргалан

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Аймгийн Засаг дарга 2018 оны 08 дугаар сарын 23-ны
 дэргэд 467 тоот захирамжийн 2 дугаар хавсралт



**ДУНГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН
 ХАӨМС-ИЙН БАЯЖИЛТ, ШИНЭЧЛЭЛТ-2018 САРЫН АЯНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хийгдэх арга хэмжээ	Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн нэгжийн гүйцэтгэх ажил, үйлчилгээ,	Хугацаа	Хариуцах газар, хэлтэс/ тасгийн нэр /албан хаагч/
1	2	3	4
1.Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны өрхийн жагсаалт бэлтгэх, ХАӨМС-н мэдээллийг сайжруулах аяныг удирдлага, зохион байгуулалтаар хангах.	1.1. Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны өрхийн жагсаалт бэлтгэх, ХАӨМС-н мэдээллийг сайжруулах аяныг удирдлага,зохион байгуулалтаар хангана. 1.2. НҮТСудалгаа болон ХАӨМС-н мэдээллийг сайжруулах аяныг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.	2018 оны 08 сарын 15-наас 9 сарын 25	Хэлтсийн дарга
2.ХАӨМС-н хариуцан ажилладаг сумын төрийн сангийн мэргэжилтэн, Багийн засаг дарга нарын утас, и-мэйл хаягийг шинэчлэх	2.1. ХАӨМС-н хариуцан ажилладаг сумын төрийн сангийн мэргэжилтэн, Багийн засаг дарга нарын утас, и-мэйл хаягийг нарийвчлан шинэчлэнэ.	2018 оны 8 сарын 15	Ахлах мэргэжилтэн
3.Шинээр нэмэгдсэн багийн мэдээллийг ХАӨМС санд оруулах	3.1. Сумдад шинээр нэмэгдсэн баг байгаа эсэхийг шалгаж лавлах, шинээр нэмэгдсэн багт хамаарагдах өрхийн дугаар бүхий жагсаалтыг ҮСХороонд хүргүүлж програмдаа шинэчлэл хийлгэх арга хэмжээ авна	2018 оны 8 сарын 25	Хүн ам хариуцсан мэргэжилтэн
4.Сумдад албан тоот хүргүүлэх	4.1. Сумдын Засаг дарга нарт ХАӨМС-г сайжруулах, НҮТС-ны бэлтгэл ажлыг хангах , ажил эрчимжүүлэх албан тоот хүргүүлэх	2018 оны 8 сарын 25	Хэлтсийн дарга
5.Сарын аяны захирамж, удирдамж, төлөвлөгөө батлуулж, сурталчилгаа хийх	4.1. Аймгийн Засаг даргын захирамж батлуулан, удирдамж, төлөвлөгөөг хэвсэргэн сумдад хүргэж, Ард ТВ-ээр сурталчилгаа, шторж цацах, уралдаан зарлах	2018 оны 8 сарын 25	Ахлах мэргэжилтэн

Хийгдэх арга хэмжээ	Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн нэгжийн гүйцэтгэх ажил, үйлчилгээ,	Хугацаа	Хариуцах газар, хэлтэс/ тасгийн нэр /албан хаагч/
6.Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааг зохион байгуулах, сонгогдсон сум багийн өрхийн жагсаалтыг чанартай гаргах	4.1. НҮТС-г орон нутагт зохион байгуулахад дэмжлэг туслалцаа үзүүлэх. 4.2. Сонгогдсон сумд багийн өрх, хүн амын мэдээллийг үнэн зөв болгох 4.3. Өрхүүдийн хаяг байршлыг тодорхой болгох, холбоо барих утасны дугаарыг шинэчлэх	2018 оны 9 сарын 05	Сумын статистик хариуцсан ажилтан, багийн Засаг дарга, Хэлтсийн дарга, мэргэжилтнүүд
7.ХАӨМС-н сангийн мэдээллийг үнэн зөв чанартай болгох	5.1.Багийн өрх, хүн амын мэдээллийг шинэчилж дуусган 09 сарын 05, 25-нд тайланг ирүүлэх 5.2. ХАӨМС-н мэдээллийг в.Халамжийн сангийн мэдээлэл /хөгжлийн бэрхшээл/ б. Боловсролын байгууллагын мэдээлэлтэй тулган шалгаж мэдээллийг сайжруулах	2018 оны 09 сарын 25	Сумын Статистик хариуцсан ажилтан, багийн Засаг дарга нар
8. ХАӨМС сангийн мэдээллийн шинэчлэлтэнд хяналт хийх	6.1. ХАӨМС сангийн мэдээллийн шинэчлэлтийн явцад логик болон бусад хяналт хийж багийн дарга нарт зөвлөн туслаж ажиллана. 6.2. АХС болон ӨНЭЗС-д хамрагдсан өрхийн мэдээллийг ХАӨМС сангийн мэдээлэлтэй тулган нарийвчилсан хяналт хийж багийн даргаар өрхийн мэдээллийг засуулна. 6.3. ХАӨМС сангийн мэдээллийн шинэчлэлтийн явцад газар дээр нь хяналт хийх, багийн дарга нарт зөвлөн тусалж хамтран ажиллана.	2018 оны 9 сарын 25	Хэлтсийн дарга, мэргэжилтнүүд, судлаачид
9.Сарын аяны ажлыг эцэслэн дүгнэх	9.1 Үнэлгээг гарган шилдэг багуудыг шагнаж урамшуулах.	2018 оны 10 сарын 01	Хэлтсийн дарга, мэргэжилтнүүд

ДУНДГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС